



IAF Mandatory Document

ОУИФ Заавал мөрдөх баримт бичиг

**ISO 22003-1:2022 СТАНДАРТЫН
ШИЛЖИЛТИЙН ШААРДЛАГА
TRANSITION REQUIREMENTS
FOR ISO 22003-1:2022**

Хэвлэл 1

(IAF MD 27:2023)

Хэвлэсэн огноо: 30.08.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 30.08.2018

Олон Улсын Итгэмжлэлийн Форум (ОУИФ) нь ОУИФ-ын гишүүнээр итгэмжлэгдсэн Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ын гаргасан үр дүнг дэлхий даяар хүлээн зөвшөөрч, Итгэмжлэлийн байгууллага (ИБ)-уудын дунд дэлхий хэмжээний харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэгч болон зохицуулагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн худалдааг хөнгөвчилдөг.

Итгэмжлэл нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ууд итгэмжлэлийн хамрах хүрээнд багтсан ажлаа гүйцэтгэх чадамжтайг батлах замаар бизнес болон тэдгээрийн хэрэглэгчдэд учрах эрсдэлийг бууруулдаг. ОУИФ-ын гишүүн ИБ болон тэдгээрийн итгэмжлэгдсэн ТҮБ-ууд нь олон улсын стандарт, тэдгээр стандартын хэрэглээний нийцтэй байдалд зориулсан ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийг мөрдөх шаардлагатай.

ОУИФ-ын Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ХХЗХ)-т нэгдсэн ИБ-уудын итгэмжлэлийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд итгэлийг бий болгохын тулд ижил түвшний багаас бүрдсэн үнэлгээг тогтмол явуулдаг. ОУИФ-ын ХХЗХ-ийн бүтцийн талаар ОУИФ-ын бодлогын баримт бичиг 3 (IAF PL 3) “ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний бүтэц ба ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний өргөтгөлийн бодлого, журам”-д дэлгэрэнгүй тусгасан. Мөн ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний талаар ОУИФ-ын ХХЗХ-ийн статус баримт бичигт тусгасан.

ОУИФ-ын ХХЗХ-ийн нь дараах таван түвшний бүтэцтэй. Үүнд:
1-р түвшин нь ISO/IEC 17011 стандартыг хэрэгжүүлэгч бүх ИБ-уудад хамаарах заавал мөрдөх шалгуурыг тодорхойлно. 2-р түвшний үйл ажиллагаа болон холбогдох 3-р түвшний норматив баримт бичиг(үүд)-ийн нэгдлийг ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээ гэж нэрлэдэг.

The International Accreditation Forum, Inc. (IAF) facilitates trade and supports industry and regulators by operating a worldwide mutual recognition arrangement among Accreditation Bodies (ABs) in order that the results issued by Conformity Assessment Bodies (CABs) accredited by IAF members can be accepted globally.

Accreditation reduces risk for business and its customers by assuring them that accredited CABs are competent to carry out the work they undertake within their scope of accreditation. ABs that are members of IAF and their accredited CABs are required to comply with appropriate international standards and IAF mandatory documents for the consistent application of those standards.

ABs that are signatories to the IAF Multilateral Recognition Arrangement (MLA) are evaluated regularly by an appointed team of peers to provide confidence in the operation of their accreditation programs. The structure of the IAF MLA is detailed in IAF PL 3 - Policies and Procedures on the IAF MLA Structure and for Expansion of the Scope of the IAF MLA. The scope of the IAF MLA is detailed in the IAF MLA Status document.

The IAF MLA is structured in five levels: Level 1 specifies mandatory criteria that apply to all ABs, ISO/IEC 17011. The combination of a Level 2 activity(ies) and the corresponding Level 3 normative document(s) is called the main scope of the MLA, and the combination of Level 4 (if applicable) and Level 5 relevant normative documents is called a sub-scope of the MLA.

4-р түвшин (хэрэв байгаа бол) болон 5-р түвшний холбогдох норматив баримт бичгийн нэгдлийг ХХЗХ-ийн дэд хамрах хүрээ гэж нэрлэдэг.

- ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээнд бүтээгдэхүүний баталгаажуулалт гэх мэт үйл ажиллагаа болон ISO/IEC 17065 зэрэг холбогдох заавал мөрдөх стандарт багтана. Үндсэн хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил найдвартай гэж үзнэ.
- ХХЗХ-ийн дэд хүрээнд тохирлын үнэлгээний шаардлагууд буюу ISO 9001 болон схемийн тусгай шаардлага, тухайлбал ISO 22003-1 стандартууд багтана. Дэд хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил тэнцүү гэж үзнэ.

ОУИФ-ын ХХЗХ нь тохирлын үнэлгээний үр дүнг зах зээл хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай итгэлийг төрүүлдэг. ОУИФ-ын ХХЗХ-т гарын үсэг зурсан ИБ-аар итгэмжлэгдсэн байгууллагын ОУИФ-ын ХХЗХ-ийн хүрээнд гаргасан баталгааг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч, улмаар олон улсын худалдааг хөнгөвчилнө.

Хэвлэл 1

Боловсруулсан: ОУИФ-ын Техникийн хороо

Баталсан: ОУИФ-ын гишүүд

Огноо: 27.07.2023

Хэвлэсэн огноо: 30.08.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 30.08.2018

Холбоо барих: Элва Нилсен

ОУИФ Нарийн бичгийн дарга

Утас: +1 613 454-8159

И-мейл: secretary@iaf.nu

- The main scope of the MLA includes activities e.g. product certification and associated mandated standards e.g. ISO/IEC 17065. The attestations made by CABs at the main scope level are considered to be equally reliable.
- The sub scope of the MLA includes conformity assessment requirements e.g. ISO 9001 and scheme specific requirements, where applicable, e.g. ISO 22003-1. The attestations made by CABs at the sub scope level are considered to be equivalent.

The IAF MLA delivers the confidence needed for market acceptance of conformity assessment outcomes. An attestation issued, within the scope of the IAF MLA, by a body that is accredited by an IAF MLA signatory AB can be recognized worldwide, thereby facilitating international trade.

Issue 1

Prepared by: IAF Technical Committee

Approved by: IAF Members

Date: 27 July 2023

Issue Date: 30 August 2023

Application Date: 30 August 2018

Name for Enquiries: Elva Nilsen

IAF Corporate Secretary

Contact Phone: +1 (613) 454 8159

Email: secretary@iaf.nu

АГУУЛГА

1. УДИРТГАЛ
2. ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ
3. ТҮЛХҮҮР ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭ
4. ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ҮЙЛ
ЯВЦЫН АРГА ХЭМЖЭЭ
 - 4.1 ИБ-ЫН АВАХ АРГА ХЭМЖЭЭ
 - 4.2 ТҮБ-ЫН АВАХ АРГА ХЭМЖЭЭ
 - 4.3 БУСАД

TABLE OF CONTENTS

1. INTRODUCTION
2. SUMMARY OF CHANGES
3. KEY TIMESCALE
4. TRANSITION PROCESS ACTIONS
 - 4.1 AB ACTIONS
 - 4.2 CAB ACTIONS
 - 4.3 OTHER

ОУИФ-ЫН ЗААВАЛ МӨРДӨХ БАРИМТ БИЧГИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байвал зохино” нэр томъёо нь шаардлагыг биелүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ. Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нь итгэмжлэлийн байгууллагад (ИБ) нотлон харуулсан ижил аргаар эдгээр шаардлагыг биелүүлнэ. Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байх ёстой” нэр томъёо нь заавал мөрдөх холбогдох стандартын шаардлагыг заана.

INTRODUCTION TO IAF MANDATORY DOCUMENTS

The term “should” is used in this document to indicate recognised means of meeting the requirements of the standard. A Conformity Assessment Body (CAB) can meet these in an equivalent way provided this can be demonstrated to an Accreditation Body (AB). The term “shall” is used in this document to indicate those provisions which, reflecting the requirements of the relevant standard, are mandatory.

ISO 22003-1:2022 СТАНДАРТЫН ШИЛЖИЛТИЙН ШААРДЛАГА

1. УДИРТГАЛ

Норматив баримт бичгийн шилжилтийн тухай мэдээллийг олгох бүх баримт бичгүүд нь энэхүү баримт бичигт нарийвчлан тусгасан хамрах хүрээнд ОУИФ-ын ХХЗХ-ийн гишүүн ИБ болон итгэмжлэгдсэн ТҮБ-уудын зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг болно. Энэхүү баримт бичгийг IAF PR 7:2022 “Шилжилтийн үед ОУИФ-ын заавал мөрдөх баримт бичгийг боловсруулах шаардлага”-ын дагуу ОУИФ-ын техникийн хорооноос томилогдсон ажлын хэсэг боловсруулсан болно.

Энэхүү баримт бичгийг ОУИФ-ын гишүүн бүх ИБ болон итгэмжлэгдсэн ТҮБ-ууд заавал мөрдөнө.

Энэхүү баримт бичиг нь дараах стандартын шилжилтийн шаардлагуудаар хангах болно.

TRANSITION REQUIREMENTS FOR ISO 22003-1:2022

1. INTRODUCTION

All documents that provide information on transitions of normative documents will be mandatory documents to be followed by IAF MLA Accreditation Bodies (AB) signatories and accredited Conformity Assessment Bodies (CABs), with the scope as detailed in this document. This document is developed by an appointed Task Force of the IAF Technical Committee and in accordance with IAF PR 7 – Requirements for Producing IAF Mandatory Documents on Transitions.

The document is mandatory for all IAF MLA AB signatories and accredited CABs.

This document provides transition requirements for:

Норматив баримт бичиг/Normative Document:	ISO 22003-1:2022
Орлож буй/Replacing:	ISO/TS 22003:2013
Одоогийн статус (ЗМББ хэвлэл) /Current Status (at the time of MD publication)	Нийтлэгдсэн/Published
Шилжилтийн хугацаа/Transition Period:	Нийтлэгдсэнээс хойш 3 жил (36 сар) 3 years (36 months) from the date of publication.

Энэхүү ЗМББ-ийг IAF PR 7-ын шаардлагын дагуу боловсруулсан тул PR 7-ын 1.2.2-т заасны дагуу схем нь онцлог шилжилтийн үйл явцыг тодорхойлж буй тохиолдолд энэ баримт бичиг хамаарахгүй.

This MD document was developed in accordance with the requirements of IAF PR 7 and therefore, per section 1.2.2 of PR 7 this document is not applicable where a scheme determines a specific transition process.

2. ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

ISO/TS 22003:2013 болон ISO 22003-1:2022 стандарт хоорондох гол өөрчлөлтүүд нь дараах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- (i) Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт (НАССР)-ын шинэ тодорхойлолт;
- (ii) 7-р зүйлийн нэмэлт/өөрчлөлт:
 - a. ТҮБ дахь баталгаажуулалтын чиг үүргийн тодорхойлолт
 - b. А хавсралтад суурилсан техникийн болон С хавсралтад суурилсан чадамжийн тогтоосон шаардлагууд
 - c. Хүнсний аюулгүй байлын мэдлэгийг үнэлэх ТҮБ-д тавих шаардлага
 - d. Ажилтны чадамжийг үнэлэх ажилтанд тавих мэдлэгийн тогтсон шаардлага
- (iii) 8-р зүйлийн нэмэлт/өөрчлөлт:
 - a. Баталгаажуулалтын баримт бичгийн хамрах хүрээнд зориулсан А.1 хүснэгтийг хэрэглэх шаардлага
 - b. Тэмдгийн ашиглалтын зааврын нэмэлт заавар
- (iv) 8-р зүйлийн нэмэлт/өөрчлөлт:
 - a. Аудитын хугацааны шаардлага
 - b. Баталгаажуулалтын хүрээг тодорхойлох шаардлага
 - c. Олон салбарын түүвэрлэлт
 - d. Анхдагч аудитын шаардлага
 - e. Анхдагч аудитын хүлээлт
 - f. Гэнэтийн аудит
- (v) А хавсралтын нэмэлт/өөрчлөлт:
 - a. ББ-ын үйл ажиллагааны дэд ангиллын түвшний тодорхойлолт
 - b. Аудитор болон аудитын багийн чадамжийн тодорхойлолт
 - c. Дэд ангилал болон кластерт орсон өөрчлөлт
 - ВIII-ийн нэмэлт - Ургамлын бүтээгдэхүүний урьдчилан боловсруулалт
 - С0-ийн нэмэлт – Малын анхдагч боловсруулалт

2. SUMMARY OF CHANGES

The main changes between ISO/TS 22003:2013 and ISO 22003-1:2022 include but are not limited to:

- (i) New HACCP Study definition;
- (ii) Changes/additions to Clause 7:
 - a. Definition of certification functions within the CAB
 - b. Establishes technical requirements based on Annex A and competence requirements based on Annex C
 - c. Requirement for CABs to evaluate food safety knowledge
 - d. Establishes knowledge requirements for evaluators of personnel competence
- (iii) Changes/additions to Clause 8:
 - a. Requirement to use Table A.1 for the scope of certification documents
 - b. Expanding guidance on the use of the marks
- (iv) Changes/additions to Clause 9:
 - a. Audit duration requirements
 - b. Requirements for defining scope of certification
 - c. Multi-site sampling
 - d. Requirements for initial audits
 - e. Initial Audit expectations
 - f. Unannounced audits
- (v) Changes/additions to Annex A:
 - a. Defines scope of CB operations to subcategory level
 - b. Defines auditor and audit team competence
 - c. Changes to subcategories and clusters
 - Addition of BIII - Pre-processing handling of plant products
 - Addition of C0 - Animal Primary conversion

- Ангиллуудыг H, I, J бүлэг болгон задласан
 - D болон G дэд ангиллыг хассан
- (vi) В хавсралтын нэмэлт/өөрчлөлт:
- a. Олон салбар болон нэгдсэн менежментийн тогтолцооны лавлагаа нэмэгдсэн
 - b. Хүснэгтийг дэд ангиллын түвшинд өргөтгөсөн
 - c. Нийт цагийн нийлбэр (FTE) болон газар дээрх аудит гүйцэтгэх хамгийн бага өдрийн тохируулга
 - d. Аудитын хугацаа тооцооллын өөрчлөлт
- (vii) С хавсралтын нэмэлт/өөрчлөлт:
- a. ISO/IEC 17021-1 стандартын А хавсралтыг нэгтгэсэн
 - b. Чадамжийн өөрчлөлт

- Separation of clusters for categories H, I and J
 - Removal of subcategories D and G
- (vi) Changes/additions to Annex B:
- a. Inclusion of references to multi-site and integrated management systems
 - b. Expanding Table to the subcategory level
 - c. Adjustment to the minimum onsite audit days & FTE considerations
 - d. Changes to audit time calculations
- (vii) Changes/additions to Annex C:
- a. Incorporation of competencies from ISO/IEC 17021-1 Annex A
 - b. Changes in competencies

3. ТҮЛХҮҮР ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭ

ISO 22003-1:2022 стандарт нь 2022 оны 6-р сард нийтлэгдсэн бөгөөд ОУИФ-ын шийдвэрийн дагуу доорх огноог 2022 оны 6-р сарын 30-ны өдрөөс тооцсон болно.

3. KEY TIMESCALE

ISO 22003-1:2022 was published in June 2022. As per IAF decision the dates below are calculated from 30 June 2022.

Үйл ажиллагаа/Activity	Дуусах огноо/Due Date
ИБ/АВ	
ИБ нь дараах хугацаанаас хэтрүүлэхгүй ISO 22003-1:2022 стандартын дагуу үнэлгээ хийхэд бэлэн болно. <i>AB to be ready to assess to ISO 22003-1:2022 no later than</i>	Баримт бичиг нийтлэгдсэнээс хойш 18 сарын дараа – 2023 оны 12-р сарын 31-ний өдөр <i>18 months from publication month of document – 31 December 2023.</i>
ИБ нь дараах хугацаанаас хэтрэхгүй бүх анхдагч итгэмжлэлийн үнэлгээнд ISO 22003-1:2022 стандартыг хэрэглэнэ. <i>AB to use ISO 22003-1:2022 for all initial accreditation assessments no later than</i>	Баримт бичиг нийтлэгдсэнээс хойш 24 сарын дараа – 2024 оны 6-р сарын 30-ны өдөр <i>24 months from publication month of document - 30 June 2024.</i>
ИБ-ын бүх ТҮБ-ууд нь дараах хугацаанаас хэтрэхгүй шилжиж дууссан байна. <i>AB transition of all CABs completed no later than</i>	Баримт бичиг нийтлэгдсэнээс хойш 30 сарын дараа – 2024 оны 12-р сарын 31-ний өдөр <i>30 months from publication month of document - 31 December 2024.</i>
ТҮБ/САВ	
ТҮБ нь ISO 22003-1:2022 стандартын дагуу итгэмжлэгдсэнийхээ дараа бүх үйлчлүүлэгч нартаа тус стандартыг ашиглаж болно. <i>CAB may use ISO 22003-1:2022 for all initial clients after accreditation for ISO 22003-1:2022</i>	Шилжилтийн хугацаанаас хамааран ББ тус бүрдээ хугацааг тодорхойлох боловч баримт бичиг хэвлэгдсэнээс хойш 24 сараас хэтрүүлэхгүй – 2024 оны 6-р сарын 30-ны өдөр эсвэл үүнээс хойш хэрэгжих итгэмжлэлийн шилжилтийн дараа <i>Date to be determined for each CB based on transition date, but no later than 24 months from publication month of document – 30 June 2024 or transition of the accreditation, whichever is later.</i>
ТҮБ нь дараах хугацаанаас хэтрэхгүй бүх үйлчлүүлэгч нартаа ISO 22003-1:2022 стандартыг ашиглана. <i>CAB to use ISO 22003-1:2022 for all clients no later than</i>	Баримт бичиг нийтлэгдсэнээс хойш 30 сарын дараа – 2024 оны 12-р сарын 31-ний өдөр <i>30 months from publication month of document - 31 December 2024.</i>

<p>**ТҮБ-ууд нь одоо байгаа үйлчлүүлэгчиддээ түүвэрлэлт болон аудитын хугацааны тооцоолол зэрэг бүх нөлөөлөх өөрчлөлтийг хийж, хэрэгжүүлсэн байна.</p> <p>**CABs to implement all changes impacting their existing clients such as sampling and audit time calculations no later than</p>	<p>Баримт бичиг нийтлэгдсэнээс хойш 36 сарын дараа – 2025 оны 6-р сарын 30-ны өдөр</p> <p><i>36 months from publication month of document - 30 June 2025.</i></p>
---	---

****Баталгаажуулалтад хамрагдсан одоо байгаа үйлчлүүлэгчдэд:**

Олон салбарын түүвэрлэлт болон аудитын хугацааг тодорхойлох шаардлага нь 2022 оны хувилбараар өөрчлөгдсөн тул ТҮБ болон үйлчлүүлэгч хоорондын байгуулсан гэрээ шинэ шаардлагын дагуу өөрчлөгдөж болно. Тус шинэчлэлт нь 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөс хэтрэхгүйгээр бүх шаардлагатай өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх ТҮБ-д шаардлагатай хугацааны дараа бүрэн хийгдсэн байна.

Шинэчлэгдсэн шаардлагын дагуу бүх үйлчлүүлэгчид 2025 оны 6-р сарын 30-ны өдөр гэхэд аудитад орсон байхаар хэрэгжүүлнэ. Үүнд, аудитад орсон ямар ч салбарын түүвэрлэлт нь цаашид хүлээн зөвшөөрөхгүй байдал мөн хамаарна.

****For existing certified clients:**

As requirements for multisite sampling and audit time determination have changed in the 2022 edition, it is acceptable that the contract between the CAB and the client is revised to follow new requirements.

The revision must be completed to allow CABs sufficient time to implement all changes necessary by no later than 31 December 2024.

Implementation must ensure that by 30 June 2025 all clients have been audited in accordance with the revised requirements, as an example any sites that are no longer eligible for sampling have been audited.

4. ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН ҮЙЛ ЯВЦЫН АРГА ХЭМЖЭЭ

4. TRANSITION PROCESS ACTIONS

4.1 ИБ-ын авах арга хэмжээ

4.1 AB Actions

Үйл ажиллагаа /Activity	Т/Ү Y/N	Тэмдэглэл	Notes
ИБ-ын зохицуулалт/ AB's Arrangements	Тийм/ Yes	<ul style="list-style-type: none"> - Дуусах огнооноос хамаарсан хамгийн эрт боломж болон сүүлийн хугацаанд шинэ хувилбараар үнэлэхэд бэлтгэх болон төлөвлөх - Шинэ болон хуучин хувилбарын өөрчлөлтүүдийг тодорхойлох - Шилжилтийн үеийн аливаа завсрын хугацааг багтаасан шилжилтийн зохицуулалтын талаар ТҮБ-тай тухай бүр харилцах - Шинэчилсэн хувилбар болон шилжилтийн үйл явцын өөрчлөлт нөлөөлөх холбогдох ажилтан нь ур чадвартай эсэхийг хангах - ТАЙЛБАР: ИБ-ууд шаардлагатай арга хэмжээг боломжит хамгийн эрт байдлаар төлөвлөж, эхлүүлэхийг уриалж байна. 	<ul style="list-style-type: none"> - Plan and prepare to be ready to assess to the new version at the earliest opportunity and at latest according to set due date. - Identify the changes between new and old version. - Ensure timely communication to CABs on required transition arrangements including any interim deadlines within the transition period. - Ensure that relevant personnel affected by the changes are competent for the revised version and transition process. - NOTE: ABs are encouraged to plan and commence required actions at the earliest opportunity.
ТҮБ-ын баримт бичгийн хяналт/ CAB Document Review	Үгүй/ No		
ТҮБ-ын техникийн баримт бичгийн хяналт/ CAB Technical Document Review	Тийм/ Yes	Хэрэгжилтийг нотлох болон бусад ИБ-ын шаардлагатай гэж үзсэн холбогдох мэдээлэл зэрэг ТҮБ-ын зөрүүгийн шинжилгээ, шилжилт/хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө, холбогдох өөрчлөлтийн баримт бичгийн хяналт	Review of the CAB's Gap Analysis, transition/implementation plan, relevant documentation for the changes including evidence of implementation and other relevant information deemed necessary by the AB.
ТҮБ-ын төв оффис дахь техникийн үнэлгээ/ Technical Assessment at CAB Head Office (on-site or remote) Review)	Хэрэв боломжтой бол/ If applicable	Хэрэв ИБ нь ТҮБ-ын техникийн баримт бичгийг хянасны үр дүнд ТҮБ-ын шаардлагатай өөрчлөлт, хэрэгжилтийг хянах боломжтой бол ТҮБ-ын төв оффис үнэлгээ шаардлагагүй. Хэрвээ ИБ нь ингэж чадахгүй бол оффис үнэлгээ шаардлагатай.	If AB is able to review required changes and implementation by CAB as a result of the CAB technical document review, then a CAB head office assessment is not required. If AB is not able to, then an office assessment is required.
ТҮБ-ын гэрчлэх	Үгүй/		

үнэлгээ/ <i>CAB Witnessed Assessment(s)</i>	No		
Бусад/ <i>Others</i>	Үгүй/ <i>No</i>		
ИБ-ын шилжилтийн шийдвэр/ <i>AB Transition Decision</i>	Тийм/ <i>Yes</i>	Тодорхойлсон бүх шийдэгдээгүй асуудлуудыг зохих ёсоор шийдвэрлэж, чадамжаа харуулсан бол шинэчилсэн баримт бичигт шилжих шийдвэр гаргана.	AB to make the transition decision, to the revised document, when all identified outstanding issues have been appropriately addressed and competence has been demonstrated.

4.2 ТҮБ-ын авах арга хэмжээ

4.2 CB Actions

Үйл ажиллагаа/ Activity	Т/Ү Y/N	Тэмдэглэл	Notes
ТҮБ-ын зохицуулалт/ CAB's Arrangements	Тийм/ Yes	<p>-Тогтоосон хугацааны дагуу шинэ шаардлагыг хэрэгжүүлэхэд бэлэн байж, шилжилтийн талаар ИБ-д өргөдөл гаргахаар төлөвлөж, бэлтгэх</p> <p>-Зөрүүний шинжилгээ хийх</p> <p>-Дараах зүйлсийг тооцсон шилжилтийн төлөвлөгөөг хөгжүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> i) Шинэ болон хуучин хувилбарын ялгааг тодорхойлох. Өөрчлөлтөд хамаарах нийтлэг үйл явцад борлуулалт болон үнийн санал, аудитын үйл явц, чадамжийн менежмент болон одоогоор баталгаажуулсан үйлчлүүлэгтэй холбогдох зэрэг багтана. ii) Хамааралтай үйл ажиллагаа/ үйл явцын өөрчлөлтийн үзүүлж буй нөлөөг шинжлэх, тохирлыг хангахад шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох. (Жишээлбэл, менежментийн тогтолцоо/баримт бичиг, МТ-ийн хэрэгслүүд) iii) Шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх <p>-Шинэчилсэн хувилбар болон шилжилтийн үйл явцын өөрчлөлт нөлөөлөх холбогдох ажилтан нь ур чадвартай эсэхийг хангах. Ажилтан нь аудитор, тайланд дүн шинжилгээ хийх ажилтан, баталгаажуулалтын шийдвэр гаргагч, гэрээ дүгнэгч, төлөвлөгөө гаргагч байж болох ба үүгээр хязгаарлагдахгүй.</p> <p>ТАЙЛБАР: ТҮБ-ууд шаардлагатай арга хэмжээг хамгийн эрт байх боломжоор төлөвлөж, эхлүүлэхийг уриалж байна.</p>	<p>-Plan and prepare to apply to AB for transition and be ready to apply new requirements according to the set due dates.</p> <p>-Complete Gap Analysis.</p> <p>-Develop transition plan to address the following:</p> <ul style="list-style-type: none"> i) Identify the changes between new and old version. Typical processes considered for changes can include sales/quoting, auditing process, competence management and communication with existing certified clients. ii) Analyze impact of changes on relevant activities/processes and identify required actions to ensure conformance (e.g. management system/documents, IT tools). iii) Implement required actions. <p>-Ensure that relevant personnel affected by the changes are competent for the revised version and transition process. Personnel may include, but not be limited to, auditor, reviewers of audit report, certification decision maker, contract reviewer, planner.</p> <p>NOTE: CABs are encouraged to plan and commence required actions at the earliest opportunity.</p>

4.3 БУСАД

Баталгаажуулалтад хамрагдсан үйлчлүүлэгчдэд тухайн өөрчлөлтүүд нөлөөлөх бөгөөд энэ нь ТҮЙ-тай хийсэн гэрээнд нөлөөлж болно. Өөрчлөлтүүдэд:

- (i) Аудитын хугацааг тодорхойлох шаардлага
- (ii) Олон салбараас түүвэр авах шаардлага
- (iii) Баталгаажуулалтын хамрах хүрээ

ISO 22003-1:2022 стандартын шилжилтийн шаардлага ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийн төгсгөл

Нэмэлт мэдээлэл:

Тус баримт бичиг болон ОУИФ-ын бусад баримт бичгийн талаарх нэмэлт мэдээллийг ОУИФ-ын гишүүн, нарийн бичгийн дарга нарын газартай холбогдоно уу.

ОУИФ-ын гишүүдийн талаарх мэдээллийг <http://www.iaf.nu>. цахим хуудаснаас авна уу.

Нарийн бичгийн дарга нарын газар:

ОУИФ-ын нарийн бичгийн дарга
Утас: +1 613 454-8159
И-мейл: secretary@iaf.nu

4.3 OTHER

Certified clients will be affected by the changes which may affect the required contract with the CAB (refer to note in section 3 identified by**).

Changes include:

- (i) Requirements for audit time determination
- (ii) Requirements for multi-site sampling
- (iii) Scope of certification

End of IAF Mandatory Document Transition Requirements for ISO 22003-1:2022

Further Information:

For further Information on this document or other IAF documents, contact any member of IAF or the IAF Secretariat.

For contact details of members of IAF see the IAF website <http://www.iaf.nu>.

Secretariat:

IAF Corporate Secretary
Telephone: +1 613 454-8159
Email: secretary@iaf.nu